



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.08.21 № 01/1626

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240102051 дугаартай “Хүн тээврийн автомашин” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтай холбоотой тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болно.

Хавсралт: 01 хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ



Тодруулгын хариу

Тендерийн нэр	<b>Хүн тээврийн автомашин</b>
Тендерийн дугаар	ЭТТХК/20240102051
Тендер зарласан огноо	2024 оны 07 дугаар сарын 25
Тендер нээх огноо	2024 оны 08 дугаар сарын 23 ←
<b>Тодруулга №1</b>	
<b>Тодруулга</b>	<b>Хариу</b>
<p>Багц 1: ТОМ ОВРЫН АВТОБУС (45 ХҮНИЙ СУУДАЛТАЙ) дээр Техникийн шалгуур үзүүлэлтэд хөдөлгүүрийн багтаамжийг 11100сс байна гэсэн нь өндөр үзүүлэлт байгаа тул энэ үзүүлэлтийг дахин нягталж бидэнд тодруулж өгнө үү? Албан бичгийг хавсралтаас үзнэ үү. Баярлалаа.</p>	<p>Багц 1: ТОМ ОВРЫН АВТОБУС (45 ХҮНИЙ СУУДАЛТАЙ) -ын Техникийн шалгуур үзүүлэлтэд дурдсан хөдөлгүүрийн багтаамж 11100 СС-ээс багагүй байна гэсэн үзүүлэлт нь өндөр үзүүлэлт биш бөгөөд энэ шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа 45 хүний суудалтай олон төрлийн автобус байдаг. Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг бууруулах боломжгүй болно.</p>
<p>Багц-3: Хүн тээврийн зориулалттай тоноглогдсон "6х6" туулах чадвар сайтай автомашин гэсэн байна.</p> <p>Багц-3 Техникийн тодорхойлолтод 6-р мөрөн дээр "6х4" харьцаатай хөтлөгчтэй гэсэн байна.</p> <p>Алинаар нь автомашинаа сонгох вэ?</p>	<p>Багц-3: Хүн тээврийн зориулалттай тоноглогдсон 6х4 туулах чадвар сайтай автомашин (30-аас доошгүй суудалтай, бүхээгтэй) байна.</p>